



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 48.


Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 3 дах хэсгийн 1 дэх заалт, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт, Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 38 дүгээр зүйлийн 38.3, Засгийн газрын 2011 оны 344 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Татварын улсын байцаагчийн ажил, үүргийн биелэлтийг дүгнэх журам”-ыг хавсраг.гаар баталсугай.
2. Журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар /Н.Бат-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2007 оны 148 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БАТТӨМӨР

2012 on tushaal

Татварын ерөнхий газрын даргын 2012
онь 7 дугаар тушаалын хавсралт

Татварын улсын /ахлах/ байцаагчийн ажил,
үүргийн биелэлтийг дүгнэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Татварын ерөнхий газрын газар, хэлтэс, УТОХГ, аймаг, нийслэл, дүүргийн Татварын газар, хэлтсийн Татварын улсын /ахлах/ байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүргийн биелэлтийг сар бүр дүгнэсэн үнэлгээ нь Татварын улсын /ахлах/ байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох үндэслэл болно.
2. Ажлын үр дүнгийн шагнал олгохдоо Монгол Улсын "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг баримтална.

Хоёр. Үр дүнгийн шагналын хувь хэмжээг тогтоох

1. Татварын ерөнхий газар, УТОХГазрын газар, хэлтсийн дарга нар, аймаг, нийслэл, дүүргийн татварын /газар/ хэлтэс, тасгийн дарга нар нь харьяа нэгжийнхээ Татварын улсын /ахлах/ байцаагчдын ажил үүргийн биелэлтийг сар бүр журмын хавсралтын дагуу дүгнэж шагналын хувь хэмжээг тодорхойлно.
2. Татварын ерөнхий газар, УТОХГ, аймаг, нийслэл, дүүргийн татварын /газар/ хэлтсийн дарга нар нь харьяа газар, хэлтэс, тасгийн дарга нарын ажил үүргийн биелэлтийн дүнг хянаж тогтоосон шагналын хувь хэмжээг өөрчилж болно.
3. Татварын улсын /ахлах/ байцаагчийн ажлын үр дүнгийн шагналын хувь хэмжээг тогтоохдоо тухайн Татварын улсын /ахлах/ байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүрэг, цаг үеийн үйл ажиллагаанд оролцсон байдал, тухайн сард ажилласан хоног, ажлын цаг ашиглалтын байдлыг харгалзаж ажилласан хоногийн өвчтэй, чөлөөтэй, тасалсан өдрүүдийг хасч тооцно.
4. Татварын улсын /ахлах/ байцаагчийн ажил, үүргийн биелэлтийг дүгнэсэн биелэлтээр дараахь журмаар ажлын үр дүнгийн шагналын хувийг тогтооно.

Татварын улсын /ахлах/ байцаагчийн ажлын үр дүнгийн үнэлгээ /биелэлтийн хувь/	Татварын улсын /ахлах/ байцаагчид олгох үр дүнгийн шагналын дүнгээс тооцох хувь
90-100 хувийн биелэлттэй бол "А" буюу "Маш сайн"	30,0 хүртэл хувь
80-89 хувийн биелэлттэй бол "В" буюу "Сайн"	20,0 хүртэл хувь
70-79 хувийн биелэлттэй бол "С" буюу "Хангалттай"	10,0 хүртэл хувь
60-69 хувийн биелэлттэй бол "Д" буюу "Дутагдалтай"	-
0-59 хувийн биелэлттэй бол "F" буюу "Хангалтгүй"	-

Гурав. Үр дүнгийн шагналын хувь хэмжээг нэгтгэн тооцох, олгох

1. Татварын ерөнхий газрын Төрийн захиргаа, удирдлагын газар нь Татварын ерөнхий газрын, УТОХГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн нь харьяа газрын, Нийслэлийн татварын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс нь нийслэлийн татварын газрын, аймаг, дүүргийн хүний нөөцийн мэргэжилтэн нь тус тус өөрсдийн татварын улсын /ахлах/ байцаагч нарын ажлын үр дүнг тооцсон үзүүлэлтийг сар бүрийн 25-ны дотор нэгтгэн шагнал олгуулах шийдвэрийг гаргуулна.

2. Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь заалтыг үндэслэн Татварын Ерөнхий газар, УТОХГ, аймаг, нийслэл, дүүргийн татварын /газар/ хэлтэс нь Татварын улсын /ахлах/ байцаагч нарын ажлын үр дүнгийн шагналыг сар бүрийн сүүлийн цалинтай хамт олгоно.

Дөрөв. Бусад зүйл

1. Үр дүнгийн шагнал авсан Татварын улсын /ахлах/ байцаагчид нь дараа оны хөрөнгө орлогын мэдүүлэгтээ нийт шагналын мөнгөн дүнг заавал мэдүүлсэн байна.

2. Сахилгын шийтгэл хүлээсэн Татварын улсын /ахлах/ байцаагчид ажлын үр дүнгийн шагналыг сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа хүртэл олгохгүй.

-000-

“Татварын улсын /ахлах/ байцаагчийн ажил,
үүргийн биелэлтийг дүгнэх журам”-ын хэвсрэлт

..... /газар, хэлтэс, тасаг/-ийн татварын улсын /ахлах / байцаагчдын
сарын ажлыг дүгнэх үзүүлэлт

Д/д	Овог нэр	Албан тушаал	Ажлын цаг ашиглалт			Үүрэг даалгаврын биелэлтийн хувь	Төлөвлөгөөт ажлын биелэлтийн хувь	Бусад ажлын биелэлтийн хувь	Дундаж хувь	Өгсөн үнэлгээ	Олгох шагналын хувь	Гарын үсэг
			Ажиллабал зохих цаг	Ажилласан цаг	Хувь							
1												
2												
3												
4												
5												
6												
7												
8												
9												
10												

Үнэлгээг хянасан:

Үнэлгээ өгсөн: